

МОНГОЛ УЛСЫН  
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/179

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, АШУУИС-ийн дүрмийн 3.3.1, 4.8.1, 4.8.6, 10.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. АШУУИС-ийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэ журмыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын дарга (Б. Зоригбаатар)-д, мөрдөж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дэд захирлууд, Салбар, Бүрэлдэхүүн, газар, албад, нийт багш, ажилтан, ажиллагсад нарт тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газрын дарга (Н. Орхон)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Н. ХҮРЭЛБААТАР



Газарчилсан  
Ажлын  
Сургууль

0053219179

## **АШУҮИС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.“Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн (цаашид АШУҮИС гэх) үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-аар Монгол Улсын хууль, тогтоомж болон АШУҮИС-ийн дүрэм, журам, захирлын тушаал, шийдвэрийн хэрэгжилт, сургалт, эрдэм шинжилгээ болон мэргэжлийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, санхүү, өмч хөрөнгийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил дутагдлыг илрүүлж, запруулахад чиглэсэн дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь АШУҮИС-ийн нэгжүүдийн үндсэн болон туслах үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, гүйцэтгэл, хэрэгжилт, хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

### **ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗАРЧИМ, ХАМРАХ ХҮРЭЭ**

2.1. Хяналт шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд дараах хууль тогтоомж, тогтоол, АШУҮИС-ийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад шаардлагатай баримт бичгүүдийг удирдлага болгоно. Үүнд:

2.1.1 Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;

2.1.2. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “ААН, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”;

2.1.3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хавсралтууд;

2.1.4. Олон улсын стандартууд;

2.1.5. АШУҮИС-ийн хөгжлийн бодлого, дүрэм, журам, заавар;

2.1.6. Дотоод үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, тайлан;

2.1.7. Бусад хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалууд;

2.2. Хяналт шинжилгээ, үнэлгээг салбар, бүрэлдэхүүн сургууль харьяа, газар, зохион байгуулалтын нэгжүүдэд батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааны тодорхой чиглэлүүдийг хамруулж төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бусаар хийж гүйцэтгэнэ.

### **ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

3.1 АШУҮИС нь хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан бүтэц, газартай байна.

3.2. Хяналт шинжилгээ, үнэлгээний газар нь АШУҮИС-ийн Захиралд ажлаа хариуцан тайлагнах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад удирдлага, бүтэц, нэгжээс хараат бус байна.

3.3. Хяналт шинжилгээ, үнэлгээний газар нь Удирдах зөвлөл болон Захиргааны зөвлөлөөс хяналт шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөнд тусгахаар гаргасан саналыг харгалзан, жилийн төлөвлөгөөг боловсруулж, сургуулийн захирлаар батлуулж ажиллана.

## ДӨРӨВ. ЭРХ, ҮҮРЭГ

### 4.1 Хяналт шинжилгээ, үнэлгээний газар:

- 4.1.1. Батлагдсан төлөвлөгөө, удирдамж, захирлын тушаалын дагуу дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэж, үнэлгээг тухай бүр гарган тайлагнах;
  - 4.1.2. Их сургуулийн дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны талаарх мэдээлэлтэй танилцах, холбогдох албан тушаалтан, багш, ажилтан, суралцагчидтай уулзалт ярилцлага хийх, хяналт шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээлэл, баримт бичгийг нэгж, албан тушаалтнаас гаргуулах, холбогдох тайлбар авах, шаардлагатай тохиолдолд нэгжийн байр, тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглах;
  - 4.1.3. Илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан, зөрчлийг арилгуулах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн тэнхимиийн багш нараас туслалцаа авах, мэргэжлийн шинжээч авч ажиллуулах, нэгдсэн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах;
  - 4.1.4. Хяналт шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд ёс зүйн дүрмийг чанд баримтлах, үнэлгээ, дүгнэлт зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах, Ажлын баримтыг зохих журмын дагуу үйлдэх, илчлэх шаардлагатай мэдээллийг нуун дарагдуулахгүй байх;
  - 4.1.5. Холбогдох нэгжүүдэд илэрсэн зөрчлийг залруулах тухай мэдэгдэх хуудас, дүгнэлтийг нэгжийн удирдлагад танилцуулж, холбогдох баримт бичигт гарын үсэг зуруулах, хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлтийг шалгалт дууссанаас хойш ажлын 3 хоногийн дотор Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын даргад танилцуулах;
  - 4.1.6. Их сургуулийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт, зөвлөгөөн зохион байгуулах;
- 4.2. Салбар, бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, эмнэлэг, сувилал, удирдлагын болон зохион байгуулалтын нэгж, тэдгээрийн ажилтан:
- 4.2.1 Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ХШҮ хийлгэх тухай хүсэлт, өргөдөл гаргах эрхтэй.
  - 4.2.2 ХШҮ-ний үйл ажиллагааг чөлөөтэй явуулах нөхцөлийг хангаж, шалгалтын явцад аливаа саад учруулахгүй байх, хууль бус шаардлага тавихгүй байх, шаардлагатай мэдээллээр ханган нээлттэй, хамтран ажиллах;
  - 4.2.3 ХШҮ-ний тайлантай танилцах, нэмэлт тайлбар, баримт өгөх;
  - 4.2.4 Үнэлгээний тайлангийн үр дүн, зөвлөмж, залруулах ажлыг заасан хугацаанд хэрэгжүүлэн ХШҮ-ний газарт тайлагнах;
  - 4.2.5 ХШҮ-ний үйл ажиллагаанд холбогдох баримт, мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй, ХШҮ-ний газраас өгсөн үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг биелүүлээгүй тохиолдолд АШУУИС-ийн хөдөлмөрийн дотоод журам, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлага тооцох;

## **ТАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

5.1. Хяналт шинжилгээ, үнэлгээний газар нь дараах төрлийн дотоод хяналт шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Төлөвлөгөөт хяналт шинжилгээ үнэлгээ;
- Мэдээллийн дагуу буюу өргөдөл гомдлын шалгалт;
- Удирдах зөвлөл болон Захирлын шийдвэрийн дагуу хийх шалгалт;

5.2. Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон дүгнэлт, зөвлөмж, саналыг хянаж, холбогдох албан тушаалтнуудад хүргүүлнэ.

5.3. Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга нь их сургуулийн захиралд хяналт шинжилгээ, үнэлгээний дүн, холбогдох дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн явц, хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагаас өгсөн зөвлөмж, шаардлагын хэрэгжилтийн явц, нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд анхаарах асуудал, холбогдох албан тушаалтан, багш, ажилтанд хариуцлага тооцуулах тухай саналыг танилцуулж шийдвэрлүүлнэ.

5.4. Хяналт шинжилгээ, үнэлгээг тодорхой бус гомдол, нэр хаяггүй мэдээллээр болон тухайн албан тушаалтан, ажлын байранд хамааралгүй агуулга, сэдвээр явуулахгүй байж болно.

5.5. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ баримт бичиг судлах, холбогдох ажилтан, ажиллагаадтай ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

## **ЗУРГАА. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН БАРИМТ, ЧАНАРЫН БАТАЛГААЖИЛТ**

6.1. Хяналт шинжилгээ, үнэлгээний газар нь хяналт шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг чандлан баримталж, бүх үйл ажиллагааг цахим, зураг, дүрсээр баримтжуулна.

6.2. Хяналт шинжилгээ, үнэлгээний газар нь хяналт шинжилгээ, үнэлгээг үйл ажиллагааны удирдамж, гүйцэтгэл, тайлан, зөвлөмж түүний мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл зэрэг үйл явцын талаарх баримтыг архивын хадгаламжийн нэгж үүсгэн ажиллана.

## **ДОЛОО. БУСАД**

7.1. Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын хяналт шинжилгээ, үнэлгээний дүнд гарсан дүгнэлт зөвлөмжийг үндэслэлгүй гэж үзвэл тухайн нэгжийн удирдлага түүнийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан АШУҮИС-ийн Захиралд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.